

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙН ГАЗАР

ШУТИС, БАТС-ийн төслийн багийн хувилбар

**НИЙСЛЭЛИЙН ИННОВАЦИЙН
ДЭД ХӨТӨЛБӨР**

(ТӨСӨЛ)

УЛААНБААТАР 2018

АГУУЛГА

НЭГ. Нийтлэг үндэслэл	3
ХОЁР. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилтууд	5
ГУРАВ. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа	5
ДӨРӨВ. Дэд хөтөлбөрийн үр нөлөө, хэрэгжилтийн үр дүн, шалгуур үзүүлэлт	8
ТАВ. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ санхүүжилтийн эх үүсвэр	17
ЗУРГАА. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт	17
ДОЛОО. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ	18

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Орчин үед мэдлэг, оюун - байгалийн нөөц баялгаас илүү аливаа улс орон, салбар, бүс нутаг, хот болон байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нэг чухал эх сурвалж болж байна. Дэлхий дахины хөгжлийн чиг хандлага “шинэ эдийн засаг” буюу “мэдлэгт суурилсан эдийн засаг”-ийн хөгжлөөр тодорхойлогдох болж, нийгэм- эдийн засагт шинжлэх ухаан технологи, инновацийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж ирлээ. Шинжлэх ухааны мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргахад чиглэсэн инновацийн үйл ажиллагаа ихээхэн эрчимжиж, инновацийн чиг баримжаа нийгэм, эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн цоо шинэ хандлагыг тодорхойлох боллоо.

Иймд улс орнууд нийгэм-эдийн засгийн бүхий л хүрээ, тэр дундаа бүс нутаг, хотуудыг инновацийн чиг хандлагаар хөгжүүлэхэд ихээхэн анхаарах болж, ялангуяа нийслэлээ инновацийн хот болгон хөгжүүлэх бодлого, стратегийг амжилттай хэрэгжүүлж байна.

Нөгөө талаар, инноваци нь өнөөгийн цаг үед өрнөж буй аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үйл явцад томоохон түлхэц болж байгаагийн зэрэгцээ улс орны нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй нэг түлхүүр хүчин зүйл болдог. Дэлхийн эдийн засгийн чуулганаас жил бүр эрхлэн гаргадаг өрсөлдөх чадварын үнэлгээний тайланд Монгол улс 2015-2016 онуудад 140 орноос 104 дүгээр байранд орсон ба дээд боловсролын хөгжлийн үзүүлэлтээр 62 дугаарт, технологийн бэлэн байдлын үзүүлэлтээр 67-рт орсон боловч инновацийн үзүүлэлтээр 97 дугаар байранд оржээ. Инновацийн түвшин ийнхүү доогуур байгаа нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг хойш татах нэг сөрөг хүчин зүйл болж байна.

Монгол улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд нийслэл Улаанбаатар хот шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг билээ. Өнөөгийн байдлаар тус хотод нийт хүн амын 45% нь оршин сууж, аж ахуйн нэгж байгууллагуудын 70 гаруй хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа ба ДНБ-ний 65% -ийг үйлдвэрлэж байна. Манай нийслэл хотын хувьд “2thinknow” мэдээллийн дата агентлагаас гаргадаг хотуудын инновацийн үнэлгээгээр 2016-2017 оны байдлаар судалгаанд хамрагдсан нийт 500 хотоос 482 дугаар байранд орсон нь ихээхэн хангалтгүй үзүүлэлт юм.

Хэдийгээр 2011-2016 онуудад “Нийслэлийн үйлдвэрлэлийн салбарт инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөр” –ийг баталж, хэрэгжүүлэн, инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх талаар зарим нэг ахиц дэвшил гарсан боловч оролцогч талуудын хоорондын уялдаа холбоо сул, инновацийн хөрөнгө оруулалт, санхүүжилтын механизм бүрдээгүй, инновацийн төсөл, хөтөлбөр, судалгааны санхүүжилт хангалтгүй хэвээр байсаар байна.

Монгол улсын болон Нийслэл хотын хөгжлийн бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжууд нь Инновацийн дэд хөтөлбөр боловсруулах хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлнэ.

Эдгээрийг тоймлон дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

- 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 19 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" бодлогын баримт бичгийн 2.2.3. Зорилт 5. "Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ" гэж;
- 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Монгол улсын Инновацийн тухай хуулийн 11.1.3. "Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх, инновацийн хөтөлбөр, төсөл боловсруулах" гэж;
- Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "3.2.30."Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ" гэж;
- Монгол улсын Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого" –ын зорилгыг "Эдийн засаг, аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт инновацийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн төрөлжилт, өрсөлдөх чадварыг бий болгох" гэж;
- Улаанбаатар хотын 2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 4.6 "Улаанбаатар хотын, хот байгуулалтын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үе шатны үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэл, хот байгуулалт, нийгэм, эдийн засгийн төлөвлөлтийн орон зайн нэгдлийг хангах шинжлэх ухаан, технологийн чадавхийг бэхжүүлэх, үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх, Улаанбаатар хотын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын технологийн шинэчлэлийг дотоод, гадаадын судалгаа боловсруулалт, техник, технологи нутагшуулах замаар шийдвэрлэх талаар арга хэмээг авч хэрэгжүүлнэ" гэж;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2-т "Нийслэлд нэн шаардлагатай ноу-хау, дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг франчайз хэлбэрээр нутагшуулах"-ыг дэмжинэ гэж;
- 2017 оны нийгэм эдийн засгийн зорилтын хүрээнд "Шинэ техник, технологи бүхий инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн талаарх бодлогын баримт бичиг боловсруулж, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин ажиллана" гэж тус тус тусгасан.
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 02 дугаар тогтоолоор 2011-2016 онд Нийслэлийн Үйлдвэрлэлийн салбарт инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлагдаж, хэрэгжилтийн хугацаа дууссан.

Иймд нийслэлийн эдийн засгийн төрөлжилтийг ханган, инновацийн тогтвортой экосистемийг бүрдүүлж, инновацийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх замаар нийслэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, инновацид суурилсан хөгжлийн загвар хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан эрх зүйн болон практик хэрэгцээ нь энэхүү Нийслэлийн инновацийн дэд хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болно.

ХОЁР. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

2.1 Шинжлэх ухаан- боловсрол- үйлдвэрлэл, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн инновацийн тогтвортой экосистемийг бүрдүүлж, гарааны бизнесийн өсөлтийг хангах, нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлуудыг орчин үеийн дэвшилтэт технологи, шинэ мэдлэг ашиглан шийдвэрлэх, өндөр технологи, мэдлэг шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх замаар Нийслэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, инновацид суурилсан хөгжлийн загвар хот болгон хөгжүүлэх үндэс суурийг бүрдүүлэхэд энэхүү дэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 “Нийслэлийн инновацийн дэд хөтөлбөр”-ийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1 Нийслэлийн инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах, эдийн засаг, аж үйлдвэрийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх, Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийг дэмжиж хэрэгжүүлнэ;

2.2.2 Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөрөнгө оруулалт, санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих, бизнесийн таатай орчинг бий болгоно;

2.2.3 Инновацийн төв, дундын оффис, лаборатори, технологийн инкубатор, технологи дамжуулах төв, үйлдвэрлэл-технологийн парк зэрэг хэлбэрээр инновацийн дэд бүтцийг хөгжүүлнэ;

2.2.4 Мэдлэг, өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, дотоод гадаадын зах зээлд гаргах, экспортлох болон гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

2.2.5 ШУТ, инновацийн талаарх мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, нийгэмд инновацийн соёлыг төлөвшүүлэх, инновацийн үйл ажиллагаанд оролцогч талуудын тогтвортой үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Дэд хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар 2018-2022 онуудад хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Нэгдүгээр үе шатанд /2018-2019 он/: Дэд хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргах, шаардлагатай дүрэм, журам боловсруулах, инновацийн дэд бүтцийн нэгжүүдийг байгуулах асуудлыг шийдвэрлэх зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийн бэлтгэл хангах үйл ажиллагаа явагдана.

3.1.2 Хоёрдугаар үе шатанд /2020-2022 он/: Дэд хөтөлбөрт тусгагдсан зорилтууд, тэдгээрийг хангах үл ажиллагааны үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

3.2 Дэд хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. Нийслэлийн инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах, эдийн засаг, аж үйлдвэрийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх, Улаанбаатар хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийг дэмжиж хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

3.2.2.1 Нийслэлийн инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төсөл шалгаруулах журмыг боловсруулж, батлуулах;

3.2.2.2 Нийслэлийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн 10-аас доошгүй төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

3.2.2.3 Их, дээд сургууль, ЭШ-ний байгууллага, МСҮТ, инженер, зохион бүтээгчид, оюутан, залуучуудын дунд нийслэлийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийн уралдаан зохион байгуулж, шилдэг төслийг шалгаруулж, урамшуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2.2.4 Инновацийн төслүүдийн бүртгэл, сонгон шалгаруулалт, хэрэгжилтийн явц, үр дүнг нээлттэй мэдээлэх, ард иргэдийн оролцоог хангахад чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулах арга хэмжээ авах;

3.2.2. Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөрөнгө оруулалт, санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих, бизнесийн таатай орчинг бий болгох зорилтын хүрээнд:

3.2.2.1. Арилжааны болон бусад банкуудтай хамтран инновацийн шилдэг төслийг санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.2.2. Засгийн газрын тусгай сангууд (Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Шинжлэх ухаан технологийн сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан г.м.)- ын хүрээнд инновацийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх ажлыг хамтран зохион байгуулах;

3.2.2.3. Инновацийн санхүүжилт, хөрөнгө оруулалт татах, инновацийн үйл ажиллагааг дэмжих, төсөл хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын ах, дүү хотууд болон гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, үндэсний болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлттэй зээл, тусламжийн хөрөнгийн 10 хүртэлх хувийг инновацийн төслийн санхүүжүүлтэд зарцуулах боломж бүрдүүлэх;

3.2.2.4. Инновацийн төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Нийслэлийн инновацийн хөгжлийг дэмжих сан”, венч хөрөнгө оруулалтын сан байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;

3.2.2.5. Нийслэлд тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хүрээлэн буй орчинд ээлтэй, үр ашигтай инновацийн бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ) үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад хөнгөлттэй зээлд хамруулах эрх зүйн боломжийг судалж хэрэгжүүлэх;

3.2.2.6. Төр-хувийн хэвшлийн түншлэл, концессийн хүрээнд нийслэлд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх инновацийн төсөл хөтөлбөрүүдийг захиалж, санхүүжүүлэх арга, хэлбэрийг судалж хэрэгжүүлэх;

3.2.3. Инновацийн төв, дундын оффис, лаборатори, технологийн инкубатор, технологи дамжуулах төв, үйлдвэрлэл-технологийн парк зэрэг хэлбэрээр инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

3.2.3.1. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, гарааны бизнесийг хөгжүүлэх зорилго бүхий “Улаанбаатар инновацийн төв”-ийн үйл ажиллагааг тогтворжуулж, өргөтгөх;

3.2.3.2. “Улаанбаатар инновацийн төв”-ийн салбар-төвүүдийг Баянхошуу, Сэлбэ орчмын бүсэд байгуулж, ажиллуулах;

3.2.3.3. Гарааны компаниудын бий болгосон инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний технологи, анхны загварыг турших зорилго бүхий лаборатори байгуулж ажиллуулах;

3.2.3.4. Технологи дамжуулах төв, технологийн инкубатор зэргийг их дээд сургууль, ЭШ-ний байгууллагуудтай хамтран байгуулж, ажиллуулах;

3.2.4. Мэдлэг, өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, дотоод гадаадын зах зээлд гаргах, экспортлох болон гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

3.2.4.1. “Улаанбаатар инноваци төв”-ын инкубаторт бойжсон болон бусад гарааны компаний бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ)-ийг зах зээлд борлуулахад туслалцаа үзүүлэх, Нийслэлийн худалдан авалтын төсвийн 5%-ыг тэдгээрийг худалдан авахад зарцуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах;

3.2.4.2. Инновацийн бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ) үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран гадаад, дотоодод үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах, оролцуулах арга хэмжээ авах;

3.2.4.3. Гарааны компаниудын оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, оюуны өмчийн хамгаалах, баталгаажуулах, үнэлэмжийг сайжруулах, технологи дамжуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

3.2.5. ШУТ, инновацийн талаарх мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, нийгэмд инновацийн соёл төлөвшүүлэх, инновацийн үйл ажиллагаанд оролцогч талуудын тогтвортой үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, инновацийн хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

- 3.2.5.1. Нийслэлийн иргэдийн инновацийн талаарх ойлголт мэдлэгийг сайжруулах, бүтээлч сэтгэлгээ, санаачилгыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээ(танин мэдэхүйн болон боловсрол олгох нэвтрүүлэг, уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн, Инновацийн аян, Инновацийн 7 хоног г.м.)-г зохион байгуулах;
- 3.2.5.2. Инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;
- 3.2.5.3. Инновацийн чиглэлээр өндөр мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, давтан сургах зорилгоор их дээд сургуулиуд, боловсролын байгууллагуудтай хамтран сургалтын олон талт хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, семинар зохион байгуулах;
- 3.2.5.4. Инновацийн хүний нөөцийн үндэсний чадавхийг бэхжүүлэх үүднээс гадаадын мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, туршлага судлах, олон улсын инновацийн арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулах, гадаадад ажиллаж, амьдарч буй чадварлаг хүний нөөцийг ашиглах, тэдний мэдлэг туршлагыг инновацийг хөгжүүлэхэд татан оролцуулж хамтран ажиллах;
- 3.2.5.5. Инновацийн шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, шилдэг зохион бүтээгч, эрдэмтэн судлаачид, инженер, инноватор, энтрепренеруудыг алдаршуулах зорилгоор Нийслэлийн инновацийн шагналыг бий болгож тогтмол олгодог болох;
- 3.2.5.6. Нийслэлийн инновацийн чадавхи, хөгжлийн түвшинг тодорхойлж, үнэлэх судалгааг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран тогтмол явуулах, инновацийн судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх;

ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Дэд хөтөлбөрийн үр нөлөөний урьдчилсан үнэлгээг дараах байдлаар тодорхойлж болно.

А. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийслэлийн эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл

1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлэх нийгмийн зорилтот бүлгүүд:
 - Төр, засгийн байгууллагууд (Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн засаг захиргааны байгууллагууд, БСШУСЯ, бусад яамд, агентлагууд)
 - Шинжлэх ухаан, боловсролын байгууллагууд (ШУА, эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулиуд)
 - Бизнесийн байгууллагууд (Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагууд, ЖДҮ болон гарааны бизнес эрхлэгчид)

- Зуучлагчид буюу түншлэлийг дэмжих инновацийн дэд бүтцийн байгууллагууд (Мэдлэг, технологи дамжуулах, нутагшуулах, бойжуулах, хөрөнгө оруулалт татах, ЭШС-ны ажлын үр дүнг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгууллагууд, бизнес инкубатор, акселератор, дундын оффис, инновацийн төв г.м.)
- Иргэд, олон нийт (хүн ам, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагууд)

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийслэлийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө:

- Нийслэлийн иргэдийн оюуны бүтээл, оюуны өмч эдийн засгийн эргэлтэнд орж, мэдлэг, өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, борлуулалт, экспортын хэмжээ нэмэгдсэнээр Улаанбаатар хотын эдийн засаг, аж үйлдвэрийн салбаруудын хөгжил эрчимжин, нийслэлийн эдийн засгийн төрөлжилт хангагдан, өрсөлдөх чадварыг дээшилнэ.
- Улаанбаатар хотод инновацийн тогтвортой экосистем бүрдэж, инновацийн үйл ажиллагааг эрчимжин, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжин тэлснээр инновацид суурилсан хөгжлийн загвар хот болгон хөгжих үндэс тавигдана.

3. Нийслэлийн засаг захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө:

- Дэд хөтөлбөрийн хэрэгжүүлснээр “Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс ШУТ-ийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Улаанбаатар хотын 2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, зэрэг 6 бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтууд хэрэгжих боломж бүрдэнэ.

4. Дэд хөтөлбөр, түүний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс дараах үр нөлөө бий болно. Үүнд:

- Мэдлэг, ШУТ-ийн ололт, инновацид тулгуурлан нийслэл Улаанбаатар хотын тулгамдсан асуудлууд оновчтой байдлаар, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрлэгдэнэ.
- Инновацийн төв, дундын оффис, лаборатори, технологийн инкубатор, технологи дамжуулах төв, үйлдвэрлэл-технологийн парк гэх зэрэг хэлбэр бүхий инновацийн хөгжингүй дэд бүтэц бий болж, инновацийн экосистем, бизнесийн таатай орчин бүрдэнэ.
- Инновацийн үйлдвэрлэл, гарааны бизнес, ЖДҮ –ийн хөгжил эрчимжиж, мэдлэг, өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, борлуулалт, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- Инновацийн үйл ажиллагаанд оролцогч талууд болох шинжлэх ухаан, боловсрол, бизнес, төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодын түншлэл, хамтын ажиллагаа өргөжин, бэхжиж, үр өгөөж дээшилнэ.

- ШУТ, инновацийн талаарх мэдлэг нийтэд түгэн дэлгэрч, хүний нөөцийг бэхжиж, нийгэмд инновацийн соёл төлөвшинө.

Б. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

1. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт нь дараах хэд хэдэн нийгмийн бүлэгт нөлөө үзүүлэхээр байна. Үүнд:

- Төр, засгийн байгууллагууд (Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн засаг захиргааны байгууллагууд, БСШУСЯ, бусад яамд, агентлагууд): Төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоо сайжрах ба нийслэлийн өмнө тулгарч буй нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг инновацийн үйл ажиллагаанд оролцогч бусад талуудын оролцоогоор үр дүнтэй шийдвэрлэх боломж бүрдэж, төрийн байгууллагуудын чадавхи сайжирна.
- Шинжлэх ухаан, боловсролын байгууллагууд (ШУА, эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулиуд): Шинжлэх ухааны мэдлэгийг дамжуулах, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх, сургаж бэлтгэж буй мэргэжилтнүүд, төгсөгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах боломжтой.
- Бизнесийн байгууллагууд (Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагууд, ЖДҮ болон гарааны бизнес эрхлэгчид): Бүтээгдэхүүн, үйлчилгээний боловсруулалтын түвшин, мэдлэг шингээлт болон үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ нэмэгдэж, эдийн засгийн үр ашиг, бүтээмж, чанар сайжирснаар улс орны эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөллийг үзүүлнэ. Мэдлэг шингэсэн, чанартай бараа, ажил, үйлчилгээг дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллах бизнесийн түншлэл өргөжинө.
- Зуучлагчид буюу түншлэлийг дэмжих инновацийн дэд бүтцийн байгууллагууд (мэдлэг, технологи дамжуулах, нутагшуулах, бойжуулах, хөрөнгө оруулалт татах, ЭШС-ны ажлын үр дүнг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгууллагууд, бизнес инкубатор, акселератор, дундын оффис, инновацийн төв г.м.): Эдгээр байгууллагуудын тоо, үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, чадавхи сайжрах ба цаашид хүчээ нэгтгэн хамтран ажиллах, нэгдсэн сүлжээ үүсгэх боломж бүрдсэнээр шинжлэх ухаан- боловсрол- төр- бизнесийг холбох, мэдлэг инновацийг дамжуулах, гарааны бизнесийг бойжуулах үндсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.
- Иргэд, олон нийт (хүн ам, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагууд): Иргэдийн ШУТ, инновацийн талаарх ойлголт мэдлэг сайжирснаар идэвхи санаачилга, бүтээлч сэтгэлгээ, хөгжиж нийгэмд инновацийн соёл төлөвшихөд эерэг үр нөлөө үзүүлнэ.

В. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө

1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн акт:

- Инновацийн тухай хууль (зохих нэмэлт өөрчлөлт оруулах);
- ЖДҮ-ийн дэмжих тухай хууль (зохих нэмэлт өөрчлөлт оруулах);
- Нийслэлийн инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төсөл шалгаруулах журмыг боловсруулж, батлуулах;
- Инновацийн төсөл санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаах журамлах;
- “Нийслэлийн инновацийн хөгжлийг дэмжих сан” байгуулах эрх зүйн үндсийг бий болгох;
- Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, оюуны өмчийн хамгаалах, баталгаажуулах, үнэлэмжийг сайжруулах, технологи дамжуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- Гарааны бизнесийг дэмжих эрх зүйг боловсронгуй болгох;

2. Хариуцах байгууллага

- Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар дэд хөтөлбөрийг хэрэгжилтийг үндсэнд нь хариуцаж ажиллана.

Г. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлэх нөлөө

1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагууд:

Бодлогын түвшинд:

- УИХ, Засгийн Газар
- БСШУСЯ, Сангийн яам болон бусад яамд, агентлагууд
- Нийслэл, дүүргийн Иргэдийн хурал

Хэрэгжилтийн түвшинд:

- Нийслэл, дүүргийн засаг захиргааны байгууллагууд
- ШУА, Эрдэм шинжилгээний байгууллагууд,
- Их дээд сургууль, политехник коллеж, МСҮТ
- Аж ахуйн нэгж, байгууллага
- Инновацийн дэд бүтцийн байгууллагууд
- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод
- Иргэд

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлэх нөлөө (шинээр бүтэц бий болох, өнөөгийн институцийг татан буулгах, бүтцийг өөрчлөн байгуулах талаар)

- Дүүргүүдэд инноваци, гарааны хөгжлийн дэмжих төвүүдийг байгуулна.

3. Дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэхтэй холбоотой төр, захиргааны байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломж:

- Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг судалж, дүн шинжилгээ хийх;
- Инновацийн хүний нөөц бэлтгэх, инновацийн талаар мэдлэг олгох, мэргэшүүлэх сургалтыг явуулах;
- Гарааны бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэх;
- Хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэл түгээх, олон нийтэд таниулах, сурталчилах;

4. Төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх боломж:

- Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг олон талт хэлбэрээр хөгжүүлэх бүрэн боломжтой.

5. Хүний нөөцөд үзүүлэх нөлөө (дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхид өөрчлөлт оруулах эсэх тухай)

- Дэд хөтөлбөрийг хэрэгжилтийг хариуцах гол байгууллага болох Нийслэлийн үйлдвэрлэл инновацийн газрын хүний нөөцийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, нэмэгдүүлэх онцын шаардлагагүй ба хэрэгжиүүлэх явцад тулгарах асуудлуудыг шийдвэрлэхэд мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэд судлаачдаас зөвлөгөө авах боломжтой.
- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага болон инновацийн дэд бүтцийн байгууллагууд (инноваци, гарааны бизнесийг дэмжих бүтцүүд)-тай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах замаар хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой.

4.2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн
Зорилт 1. “Нийслэлийн инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах, эдийн засаг, аж үйлдвэрийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх, Улаанбаатар хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийг дэмжиж хэрэгжүүлэх” хүрээнд:	
1.1 Нийслэлийн инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төсөл шалгаруулах журмыг боловсруулж, батлуулах;	1.1. Инновацийн төсөл шалгаруулах журмыг боловсруулж, батлуулсан байна.
1.2 Нийслэлийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн 10-аас доошгүй төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	1.2 Нийслэлийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн 10-аас доошгүй төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлсэн байна.
1.3 Их, дээд сургууль, ЭШ-ний байгууллага, МСҮТ, инженер, зохион бүтээгчид, оюутан, залуучуудын дунд нийслэлийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийн	1.3 Инновацийн төслийн уралдаан зохион байгуулж, шилдэг төслийг шалгаруулж, урамшуулан, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

<p>уралдаан зохион байгуулж, шилдэг төслийг шалгаруулж, урамшуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>1.4 Инновацийн төслүүдийн бүртгэл, сонгон шалгаруулалт, хэрэгжилтийн явц, үр дүнг нээлттэй мэдээлэх, ард иргэдийн оролцоог хангахад чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулах арга хэмжээ авах;</p>	<p>1.4 Инновацийн төслүүдийн бүртгэл, сонгон шалгаруулалт, хэрэгжилтийн явц, үр дүнг нээлттэй мэдээлж, ард иргэдийн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>
<p>Зорилт 2. “Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөрөнгө оруулалт, санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих, бизнесийн таатай орчинг бий болгох” хүрээнд:</p>	
<p>2.1 Арилжааны болон бусад банкуудтай хамтран инновацийн шилдэг төслийг санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>2.2 Засгийн газрын тусгай сангууд (Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Шинжлэх ухаан технологийн сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан г.м.)- ын хүрээнд инновацийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх ажлыг хамтран зохион байгуулах;</p> <p>2.1 Инновацийн санхүүжилт, хөрөнгө оруулалт татах, инновацийн үйл ажиллагааг дэмжих, төсөл хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын ах, дүү хотууд болон гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, үндэсний болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлттэй зээл, тусламжийн хөрөнгийн 10 хүртэлх хувийг инновацийн төслийн санхүүжүүлтэд зарцуулах боломж бүрдүүлэх;</p> <p>2.4 Инновацийн төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Нийслэлийн инновацийн хөгжлийг дэмжих сан”, венч хөрөнгө оруулалтын сан байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;</p> <p>2.5 Нийслэлд тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хүрээлэн буй орчинд ээлтэй, үр ашигтай инновацийн бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ) үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад хөнгөлттэй зээлд хамруулах эрх зүйн боломжийг судалж хэрэгжүүлэх;</p> <p>2.6 Төр-хувийн хэвшлийн түншлэл, концессийн хүрээнд нийслэлд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх инновацийн төсөл хөтөлбөрүүдийг захиалж, санхүүжүүлэх арга, хэлбэрийг судалж хэрэгжүүлэх;</p>	<p>2.1 Арилжааны болон бусад банкуудтай хамтран инновацийн шилдэг төслийг санхүүжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>2.2 Засгийн газрын тусгай сангуудтай хамтран инновацийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийсэн байна.</p> <p>2.3 Инновацийн санхүүжилт, хөрөнгө оруулалт татах чиглэлээр Улаанбаатар хотын ах, дүү хотууд болон гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн байх ба үндэсний болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлттэй зээл, тусламжийн хөрөнгийн 10 хүртэлх хувийг инновацийн төслийн санхүүжүүлтэд зарцуулах боломжийг бүрдүүлсэн байна.</p> <p>2.4 “Нийслэлийн инновацийн хөгжлийг дэмжих сан”, венч хөрөнгө оруулалтын сан байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэсэн байна.</p> <p>2.5 Инновацийн бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ) үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад хөнгөлттэй зээлд хамруулах эрх зүйн боломжийг судалж хэрэгжүүлсэн байна.</p> <p>2.6 Төр-хувийн хэвшлийн түншлэл, концессийн хүрээнд нийслэлд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх инновацийн төсөл хөтөлбөрүүдийг захиалж, санхүүжүүлэх арга, хэлбэрийг судалж, хэрэгжүүлсэн байна.</p>

<p>Зорилт 3. “Инновацийн төв, дундын оффис, лаборатори, технологийн инкубатор, технологи дамжуулах төв, үйлдвэрлэл-технологийн парк зэрэг хэлбэрээр инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх” хүрээнд:</p>	
<p>3.1 Олон улсад өрсөлдөх чадвар бүхий инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, гарааны бизнесийг хөгжүүлэх зорилго бүхий “Улаанбаатар инновацийн төв”-ийн үйл ажиллагааг тогтворжуулж, өргөтгөх;</p> <p>3.2 “Улаанбаатар инноваци төв”-ийн салбар-төвүүдийг Баянхошуу, Сэлбэ орчмын бүсэд байгуулж, ажиллуулах;</p> <p>3.3 Гарааны компанийн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний технологи, анхны загварыг турших зорилго бүхий лаборатори байгуулж ажиллуулах;</p> <p>3.4. Технологи дамжуулах төв, технологийн инкубатор зэргийг их дээд сургууль, ЭШ-ний байгууллагуудтай хамтран байгуулж, ажиллуулах;</p>	<p>3.1 “Улаанбаатар инновацийн төв”-ийн үйл ажиллагааг тогтворжуулж, цар хүрээг өргөтгөжүүлсэн байна.</p> <p>3.2 “Улаанбаатар инновацийн төв”-ийн салбар-төвүүдийг Баянхошуу, Сэлбэ орчмын бүсэд байгуулсан байна.</p> <p>3.3 Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний технологи, анхны загварын туршилтын лаборатори байгуулсан байна.</p> <p>3.4. Технологи дамжуулах төв, технологийн инкубатор зэргийг их дээд сургууль, ЭШ-ний байгууллагуудтай хамтран байгуулж, ажиллуулсан байна.</p>
<p>Зорилт 4. “Мэдлэг, өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, дотоод гадаадын зах зээлд гаргах, экспортлох болон гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” хүрээнд:</p>	
<p>4.1 “Улаанбаатар инновацийн төв”-ийн инкубаторт бойжсон болон бусад гарааны компанийн бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ)-ийг зах зээлд борлуулахад туслалцаа үзүүлэх, Нийслэлийн худалдан авалтын төсвийн 5%-ийг тэдгээрийг худалдан авахад зарцуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах;</p> <p>4.2 Инновацийн бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ) үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран гадаад, дотоодод үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах, оролцуулах арга хэмжээ авах;</p> <p>4.3 Гарааны компаниудын оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, оюуны өмчийн хамгаалах, баталгаажуулах, үнэлэмжийг сайжруулах, технологи дамжуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;</p>	<p>4.1 Инновацийн бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ)-ийг зах зээлд борлуулахад туслалцаа үзүүлж, Нийслэлийн худалдан авалтын төсвийн 5%-ийг тэдгээрийг худалдан авахад зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p> <p>4.2 Гадаад, дотоодод инновацийн чиглэлээр үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах, инновацийн үйлдвэрлэгчдийг оролцуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</p> <p>4.3 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдгээрийг хамгаалах, баталгаажуулах, үнэлэмжийг сайжруулах, технологи дамжуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгосон байна.</p>
<p>Зорилт 5. “ШУТ, инновацийн талаарх мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, нийгэмд инновацийн соёл төлөвшүүлэх, инновацийн үйл ажиллагаанд оролцогч талуудын тогтвортой үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, инновацийн хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” хүрээнд:</p>	
<p>5.1 Нийслэлийн иргэдийн инновацийн талаарх ойлголт мэдлэгийг сайжруулах, бүтээлч сэтгэлгээ, санаачилгыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээ(танин мэдэхүйн болон боловсрол олгох нэвтрүүлэг, уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн,</p>	<p>5.1 Нийслэлийн иргэдийн инновацийн талаарх ойлголт мэдлэгийг сайжруулах, бүтээлч сэтгэлгээ, санаачилгыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.</p>

<p>Инновацийн аян, Инновацийн 7 хоног г.м.)-г зохион байгуулах;</p> <p>5.2 Инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;</p> <p>5.3 Инновацийн чиглэлээр өндөр мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, давтан сургах зорилгоор их дээд сургуулиуд, боловсролын байгууллагуудтай хамтран сургалтын олон талт хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, семинар зохион байгуулах;</p> <p>5.4 Инновацийн хүний нөөцийн үндэсний чадавхийг бэхжүүлэх үүднээс гадаадын мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, туршлага судлах, олон улсын инновацийн арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулах, гадаадад ажиллаж, амьдарч буй чадварлаг хүний нөөцийг ашиглах, тэдний мэдлэг туршлагыг инновацийг хөгжүүлэхэд татан оролцуулж хамтран ажиллах;</p> <p>5.5 Инновацийн шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, шилдэг зохион бүтээгч, эрдэмтэн судлаачид, инженер, инноватор, энтрепренеруудыг алдаршуулах зорилгоор Нийслэлийн инновацийн шагналыг бий болгож тогтмол олгодог болох;</p> <p>5.6 Нийслэлийн инновацийн чадавхи, хөгжлийн түвшинг тодорхойлж, үнэлэх судалгааг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран тогтмол явуулах, инновацийн судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх;</p>	<p>5.2 Инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.</p> <p>5.3 Их дээд сургуулиуд, боловсролын байгууллагуудтай хамтран Инновацийн сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулсан байна.</p> <p>5.4 Инновацийн чиглэлийн гадаадын мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, олон улсын инновацийн арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулан, гадаадад ажиллаж, амьдарч буй чадварлаг хүний нөөцийг инновацийг хөгжүүлэхэд татан оролцуулах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>5.5 Нийслэлийн инновацийн шагналыг бий болгож тогтмол олгодог болсон байна.</p> <p>5.6 Нийслэлийн инновацийн чадавхи, хөгжлийн түвшинг тодорхойлж, үнэлэх судалгааг тогтмол явуулж, инновацийн судалгааны мэдээллийн сан бүрдүүлсэн байна.</p>
--	--

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт (Хэмжих нэгж)	Хүрэх түвшин, оноор				
		2018	2019	2020	2021	2022
I.	Зорилт 1. “Нийслэлийн инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах, эдийн засаг, аж үйлдвэрийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх, Улаанбаатар хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийг дэмжиж хэрэгжүүлэх”					
1.	Инновацийн төсөл шалгаруулах батлагдсан дүрэм журам, тоо	2	2	2	2	2
2.	Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэх чиглэлээр хэрэгжсэн инновацийн төслийн тоо	1	2	3	3	3

3.	Инновацийн шилдэг төслийн уралдаант шалгаруулалтын тоо	1	2	2	2	2
4.	Инновацийн төслийн бүртгэл, шалгаруулалт, хэрэгжилтийн мэдээллийн сан үүсгэсэн байдал	-	1	1	1	1
II.	Зорилт 2. “Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөрөнгө оруулалт, санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих, бизнесийн таатай орчинг бий болгох”					
5.	Арилжааны банкууд болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн инновацийн төслийн тоо	3	3	3	3	3
6.	Инновацийн төслүүдэд оруулсан хөрөнгө оруулалт		1.0	1.0	1.0	1.0
7.	Нийслэлээс Инновацийн төвд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, тэрбум төг.	1.0	1.0	1.0	1.0	1.0
8.	Үндэсний болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс инновацийн төсөлд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, хувь	10%	10%	10%	10%	10%
9.	Олон улсын байгууллагуудтай хамтран нийслэлд хэрэгжүүлсэн инновацийн төслийн тоо	2	2	2	2	2
10.	Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлсэн инновацийн төслийн тоо	1	1	1	1	1
III.	Зорилт 3. “Инновацийн төв, дундын оффис, лаборатори, технологийн инкубатор, технологи дамжуулах төв, үйлдвэрлэл-технологийн парк зэрэг хэлбэрээр инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх”					
11.	Байгуулагдсан “Улаанбаатар инновацийн төв”-ийн тоо	1	1	1	1	1
12.	Инновацийн бүтээгдэхүүний анхны загварын туршилтын лабораторийн тоо	1	1	1	1	1
13.	Үйлдвэрлэл, инновацийг цогцоор хөгжүүлэх дэд төвүүдийн тоо	2	1	1	1	1
14.	Их дээд сургууль, ЭШ-ний байгууллагатай хамтран байгуулсан инновацийн дэд бүтцийн нэгжийн тоо	1	1	1	1	1
IV.	Зорилт 4. “Мэдлэг, өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, дотоод гадаадын зах зээлд гаргах, экспортлох болон гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх”					
15.	Инноваци хөгжлийн төвөөс бойжин гарсан гарааны компаний тоо	10	10	10	10	10
16.	Экспортолсон инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээний өсөлт, хувиар	5%	5%	5%	5%	5%
17.	Нийслэлийн худалдан авалтын төсвөөс инновацийн бүтээгдэхүүн /ажил, үйлчилгээ/-ийг худалдан авахад зарцуулсан хөрөнгийн хувь хэмжээ	5%	5%	5%	5%	5%
18.	Гадаадад туршлага судалсан болон оролцсон инновацийн үзэсгэлэн худалдаа, бусад арга хэмжээний тоо	1	2	2	2	2
19.	Инновацийн стандарт, шалгуур үзүүлэлтийн судалгаанд үндэслэн гаргасан аргачлалын дагуу “Нийслэлийн инновацийн	1	1	1	1	1

	хөгжлийн түвшин"-ний жил тутмын үнэлгээ, тоо					
Ү.	Зорилт 5. “ШУТ, инновацийн талаарх мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, нийгэмд инновацийн соёл төлөвшүүлэх, инновацийн үйл ажиллагаанд оролцогч талуудын тогтвортой үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, инновацийн хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх”					
20.	Инновацийн мэдлэг олгох, мэдээлэл түгээх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	6	12	12	12	12
21.	Инновацийн сургалтанд хамрагдсан хүний тоо	50	100	100	100	100
22.	Инновацийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	20	200	200	200	200
23.	Нийслэл хотын “Инновацийн шагнал” олголт, тоо	1	1	1	1	1

ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

- 5.1 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:
- 5.1.1 Улсын болон Нийслэлийн төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх хөрөнгө оруулалт, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;
 - 5.1.2 Олон улс, хандивлагч орнууд болон олон улсын санхүү ба хамтын ажиллагааны байгууллагуудын урт болон богино хугацааны хөнгөлттэй зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт;
 - 5.1.3 Төр хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт, санхүүжилт
 - 5.1.4 Иргэд, гадаад, дотоодын аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт;
 - 5.1.5 Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 6.1 Нийслэлийн үйлдвэрлэл, инновацийн газар нь дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аргачлал, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 6.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Нийслэлийн үйлдвэрлэл, инновацийн газар дараах эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:
- 6.2.1 Хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулаж батлах, хэрэгжүүлэх;
 - 6.2.2 Инновацийн үйл ажиллагаанд оролцогч талууд болох Нийслэлийн агентлагууд, төрийн захиргааны төв байгууллагууд, хувийн хэвшил, шинжлэх ухаан, боловсролын болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодын оролцоог хангах, уялдуулан зохион байгуулах;
 - 6.2.3 Шаардлагатай төсөв, хөрөнгийн тооцоо хийж, санал боловсруулан холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн тухайн жилийн нийт төсөвт тусгуулан батлуулах;

- 6.2.4 Нийслэлийн агентлагуудтай өөрийн чиг үүрэгт тусагагдсан ажлын хүрээнд хамтран ажиллах;
- 6.2.5 Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан бодлого, арга хэмжээний хүрээнд тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан зарцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд батлагдсан хуваарийн дагуу тайлагнах;
- 6.2.6 Нийслэлд инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, стратегийн шийдвэр гаргах үүрэг бүхий “Нийслэлийн инновацийн зөвлөл”-ийг байгуулж, ажиллуулах;

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хяналт тавьж, нийслэл хотын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий байгууллага хагас болон бүтэн жилээр хяналт-шилжилгээ хийнэ.
- 7.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг Нийслэлийн үйлдвэрлэл, инновацийн газар боловсруулж жил бүр олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.
- 7.3 Хяналт-шинжилгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 7.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг гаргах ба эцсийн үр дүнгийн үнэлгээг судалгаа, шинжилгээний мэргэжлийн хөндлөнгийн байгууллагын оролцоотойгоор болон бие даасан мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

---oOo---